



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 1/14

Номгон

Г 7  
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр  
2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17/59 дүгээр аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай тогтоолын 2 дугаар хавсралтын 236 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардалд 4.200.000 (Дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

842311981

Аймгийн Засаг даргын ...-ны ...-ны  
 өдрийн ... дүгээр ...-ны  
 хавсралт



ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах ажил, арга хэмжээ	Төсөв сая, төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6	7	8
<b>Зорилт 1. “Шадар сайдтай хамтран ажиллах гэрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах” ажлын хүрээнд</b>							
1.1	Шударга Өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн албан бичиг, үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах	-	Ажил арга хэмжээ, үүрэг чиглэлийн хэрэгжилтийн хувиар	100%	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
1.2	Олон Улсын хэрэглэгчийн өдөр буюу 3 дугаар сарын 15-ны өдрийг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах	-	Удирдамж боловсруулан батлуулж арга хэмжээг зохион байгуулан хэрэгжилтийг тайлагнасан байна.	1	Эхний хагас жил 100%	3 дугаар сард	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
1.3	Зах зээлд бизнес эрхлэгчдийг шударгаар өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөний зарчимд бүрэн нийцүүлэх, өрсөлдөөний соёл, ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах	-	Өрсөлдөөний тухай хуулиар аж ахуй нэгж эрхлэгч, шатахуун түгээх станцууд, хүнсний үйлдвэр эрхлэгчдэд сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна.	1	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	3,9 сард	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
1.4	Бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдол, үнийн хөөргөдлийн эсрэг аж ахуй эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэх	-	Аж ахуйн эрхлэгчдэд 2 удаа зөвлөмж хүргүүлсэн байна.	1	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	1.9 сард	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан

1	2	3	4	5	6	7	8
1.5	Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн Хэрэглэгчийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх	-	Хэрэглэгчийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдол санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	21	Эхний хагас жил 100% Сүүлийн хагас жил -100%	Тухай бүр	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
1.6	Өрсөлдөөний хууль, Хэрэглэгчийн хууль, Зар сурталчилгааны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг ШӨХТГ-т өгч ажиллах	-	Хуулийн төсөлд санал өгч ажилласан байна.			Тухай бүр	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
<b>Зорилт 2. Хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсрол олгох</b>							
2.1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор тусгай удирдамж боловсруулан аян зарлаж зохион байгуулах	500.000	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг иргэд олон нийтэд суртачилах, хэрэглэгчийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай удирдамж боловсруулан аян зарлаж зохион байгуулах	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан Баянхонгор аймаг дахь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
2.2	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль Өрсөлдөөний тухай хуулийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах, сургалт зохион байгуулах	1.000.000	Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Баацагаан, Галуут, Заг, Жаргалант, Баян-Овоо, Эрдэнэцогт, Баянхонгор сумдын иргэд албан хаагчид аж ахуй нэгжүүдэд хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад хууль	10 сум	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан Баянхонгор аймаг дахь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг

1	2	3	4	5	6	7	8
			тогтоомжоор сургалт зохион байгуулна				
2.3	Хэрэглэгчийн эрх, аж ахуй нэгжийн чиг үүргийг тодорхойлсон видео контент бүтээх	500.000	Хэрэглэгчийн эрх, аж ахуй нэгжийн чиг үүргийг тодорхойлсон видео контент 2 бүтээж олон нийтийн хэрэгслээр сурталчилсан байна.	1	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан Баянхонгор аймаг дахь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
2.4	Сумдын Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг болон шинжээч нарыг оролцуулсан чуулган, хэлэлцүүлэг зохион байгуулах	2.200.000	Аймгийн 20 сумдын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Нийгэмлэгийн гишүүд болон шинжээч нарыг оролцуулсан чуулган, хэлэлцүүлгийг зохион байгуулж тулгамдаж буй асуудлыг тодорхойлон холбогдох байгууллагад уламжлан шийдвэр лүүлсэн байна.	-	Эхний хагас жил 100%	2024.01.10 2024.06.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан Баянхонгор аймаг дахь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
<b>Зорилт 3. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинд хяналт тавих</b>							
3.1	Аймгийн төвийн хүнсний дэлгүүрүүдийн бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийж зөвлөмж өгөх.	-	Хяналт шалгалтыг 2 удаа хийгдсэн байна	2	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
3.2	Аймгийн төвийн Хүнсний үйлдвэрүүдэд бараа бүтээгдэхүүний хаяг шошгын мэдээлэл, бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, эрүүл ахуй стандартад	-	Аяныг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан байна.	2	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан

1	2	3	4	5	6	7	8
	Хүнсний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад хуульд заасан эрх үүргийн хүрээнд хяналт, шалгалт хийж зөвлөмж өгөх.						
3.3	Цаг үеийн шинж чанартай хяналт шалгалтууд тухай бүр зохион байгуулах /Цагаан сар, Өвөлжилтийн нөхцөл байдал, Мах, гурил, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнийн талаарх хяналт шалгалт/	-	Цаг үеийн шинж чанартай хяналт шалгалтууд тухай бүр зохион байгуулж зөрчлийг арилгуулж ажилласан байна.	3	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
3.4	Сумдын хүнсний дэлгүүр, зах худалдааны төвийн хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацаа, эрүүл ахуйд Хэрэглэгчдээс тандалтын судалгаа авч зөрчлийг арилгах зөвлөмж хүргэх	-	Тандалт судалгааг 1 удаа хийнэ	1	Сүүлийн хагас жил -100%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
3.5	Чиг үүргийн хүрээнд ШӨХТГ-ын ажлын хэсэгтэй хамтран Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-	Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.		Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан
3.6	Гол нэрийн болон Өргөн хэрэглээний хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн судалгааг улирал бүр авч нэгтгэн ШӨХТГ-т хүргүүлэх	-	Өргөн хэрэглээний хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн судалгааг улирал бүр авч нэгтгэн ШӨХТГ-т хүргүүлэн сан бүрдүүлсэн байна.		Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан